



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2024. 07.03 № 1/2024

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ КОМПАНИУДАД

Эрчим хүчний яамнаас зарласан “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачаалалд ажиллах тархмал дулааны эх үүсвэр /Улаанбаатар/” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохоор сонирхож буй компаниас 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн тодруулга асуултын хариултыг хавсралтаар хүргүүлж байна.


Хавсралт 4 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  Н.ТАВИНБЭХ



170600001718

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн
даргын 2024 оны 2 дугаар сарын 08-ны
өдрийн 42017 тоот албан бичгийн хавсралт



**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН
ОРГИЛ АЧААЛАЛД АЖИЛЛАХ ТАРХМАЛ ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭР
/УЛААНБААТАР/” ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ**

2024.06.17-нд ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГЫН ХАРИУ:

Тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан:

1. ТШЗ 10.1-т “Үүнээс 2024 онд санхүүжих дүн: 20,000,000,000 төгрөг” гэснийг тайлбарлана уу.

Хариулт: Тухайн төсөл арга хэмжээ нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Эрчим хүчний сайдын багцад 60 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024-2026 онуудад хэрэгжихээр батлагдсан. Үүнээс 2024 онд барилга угсралтын ажлын гүйцэтгэлээр олгогдох мөнгөн дүнгийн дээд хэмжээ 20 тэрбум төгрөг байна.

2. ТШЗ 10.1-т заасан “Тендерийн ирүүлэхийн өмнөх уулзалт”-ыг 2024.07.01-ээс өмнө 6-р сарын сүүлийн долоо хоногт хийх боломжтой эсэх. /МУ-д өнөөдрийн байдлаар иж бүрэн хийн дулааны станц барьсан туршлагатай Монголын компани байхгүй байгааг тооцож гадны компанитай түншлэл хийхэд ихээхэн хугацаа шаардагдахаар байгааг харгалзан үзэх/

Хариулт: Тухайн төсөл, арга хэмжээний ТЭЗҮ болон ажлын даалгавартай нягтлан танилцах хугацааг тооцсон тул тендерийн өмнөх уулзалтыг ТШЗ 10.1-т заасан хугацаанд хийнэ.

3. ТШЗ 17.4-д “түншлэлийн эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-ээс дээш хувийг” гэснийг санхүүгийн чадавхийн буюу нийт төсөвт өртөгийн 40 хувийг хангасан байх гэж ойлгож болох эсэх.

Хариулт: Түншлэлийн эрх бүхий гишүүн ТШЗ 18, 19-д заасан санхүүгийн чадавхийн шаардлага, техникийн чадавхи болон туршлагын шаардлагын 40-ээс дээш хувийг тус тус хангасан байна.

4. ТШЗ 19.1-ийн 2-д Ажил гүйцэтгэх тоног төхөөрөмж: “Шаардана” гэсэн байгаа нь ямар тоног төхөөрөмж шаардсан болох нь тодорхойгүй байгааг тодорхой болгож өгнө үү.

Хариулт: Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Гэрээт байж болно.

№	Машин механизм, тоног төхөөрөмж	Хүчин чадал	Тоо ширхэг
1	Авто кран	25 тн	1
2	Экскаватор	-	1
3	Ачааны машин	25 тн	1

5. ТШЗ 19.1-ийн “3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана” Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй, нэгжийн хүчин чадал 14 МВт-иас доошгүй хүчин чадалтай иж бүрэн хийн дулааны станцын барилга байгууламжийн угсралтын ажлыг 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь 1 удаа хийж гүйцэтгэсэн байх” гэсэнтэй холбогдуулан:

5.1/ Иж бүрэн хийн дулааны станц гэсэн ойлголтыг тайлбарлана уу.

Хариулт: 14 МВт-иас доошгүй нэгжийн хүчин чадалтай хийгээр галладаг иж бүрэн дулаан үйлдвэрлэх эх үүсвэр, хийн хангамжийн системийн хамт.

5.2/ Түншлэлийн эрх бүхий гишүүн нь иж бүрэн хийн дулааны станцын үндсэн гүйцэтгэгч эсхүл туслан гүйцэтгэгчээр ажилласан байх эсэхийг тодруулж өгнө үү.

Хариулт: Үндсэн болон туслан гүйцэтгэгчээр ажилласан туршлагыг тооцно.

5.3/ Хийн дулааны станцын ажлын туршлагын төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас бага эсхүл хүчин чадал 14 МВт-аас бага тохиолдолд туршлагад тооцох эсэх.

Хариулт: Тооцохгүй. Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-т 3.Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй, нэгжийн хүчин чадал 14 МВт-иас доошгүй хүчин чадалтай иж бүрэн хийн дулааны станц, 50 м³-ээс доошгүй эзэлхүүнтэй хий хадгалах сав, барилга байгууламжийн угсралтын ажлыг 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь 1 удаа хийж гүйцэтгэсэн байх гэж заасан.

5.4/ Монгол Улсад өнөөдрийн байдлаар иж бүрэн хийн дулааны станц барьсан туршлагатай Монголын компани байхгүй байгааг харгалзан үзэж уламжлалт нүүрсэн дулааны станц барьсан туршлагыг тооцон үзэх боломжтой эсэх.

Хариулт: Боломжгүй.

6. ТШЗ 19.3 “Тусгай зөвшөөрлийн хуулбарыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулан ирүүлнэ” – Баталгаажуулна гэснийг тайлбарлана уу. Мөн “Тендерт оролцогч компани нь тухайн улсад эсхүл Монгол улсад мөрдөгдөж байгаа холбогдох журмын дагуу доорхи ажлуудыг гүйцэтгэхийг зөвшөөрсөн эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байна” гэж заасанд хийн хангамжтай холбоотой зураг төсөл боловсруулах холбогдох тусгай зөвшөөрлүүд, Эрчим хүчний яамнаас олгодог 0,7-16 кг/см² ба түүнээс дээш даралттай даралтат савны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, БХБЯ-наас олгодог хийн хангамжийн байгууламжийн технологийн угсралтын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, шатдаг хий импортлох болон бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг шаардах эсэх.

Хариулт: Тус тендерийн шаардлагатай тусгай зөвшөөрлийг Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.3-т заасан.

Тусгай зөвшөөрлийн хуулбарыг эрх бүхий байгууллага буюу нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.

7. ТШЗ 21.6-д Тендерийн баталгаа: Ирүүлнэ. Ямар хэмжээний баталгаа ирүүлэхийг тодорхой болгоно уу.

Хариулт: Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ **Error! Reference source not found.**1-д заасны дагуу “Тендерийн баталгааны дүн: 300,000,000.0 /Гурван зуун сая/ төгрөг.” байна.

8. ТШЗ 37.1-д “Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.” – Гүйцэтгэлийн баталгааны хувь хэмжээг тодорхой болгож өгнө үү. 3 эсхүл 5 хувь эсэх.

Хариулт: Гүйцэтгэлийн баталгааны хувь хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор тус төсөл арга хэмжээний тухайн төсвийн жилд санхүүжих дүн буюу 20 тэрбум төгрөгийн 3 хувиар тооцож, холбогдох хууль, журамд нийцүүлэн захиалагчид ирүүлнэ.

9. Ажлын даалгавартай танилцахад Төслийн агуулга хэсэгт “. . . 1-р үе шатанд сонирхогч этгээд техникийн санал ирүүлэх, үүний дараа тендерийн баримт бичгийг эцэслэн боловсруулж, тендерийн урилгыг 1-р үе шатанд оролцсон этгээдэд хүргүүлнэ” гэсэн нь тендер хоёр үе шаттай байхаар харагдаж байна. Эхний үе шатанд “Expression of interest” буюу Оролцох сонирхолоо илэрхийлэх хүсэлт хүлээн авах гэж ойлгогдож байна. Үүнийг тайлбарлана уу. Үнийн санал хэрхэн үнэлэгдэх Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-т талаар тайлбар алга байна.

Хариулт: Тендерийн баримт бичгийн урилгын 9-д Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: “Тийм” гэж заасан.

Хоёр үе шаттай тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлд заасныг баримтлан явуулна.

10. ТШЗ 16.1.2-д “Тухайн улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер зарласан өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай” гэснийг Тухайн улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээх өдрийн байдлаар гэж өөрчлөх боломжтой эсэх:

Хариулт: Боломжгүй. ТШЗ 16.2.3-т заасны дагуу Тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

Ажлын даалгавартай холбогдуулан:

11. Ажлын даалгавартай танилцахад Захиалагчаас энэхүү Хийн дулааны станцыг түлхүүр гардуулах нөхцлөөр явуулахаар төлөвлөж байгаа гэж ойлгогдож байна. Үүнийг тодорхой болгож өгнө үү. Тендерийн хуульд орсон саяхны нэмэлт өөрчлөлтөөр Захиалагч нь Эрх бүхий байгууллагаар Ажлын зураг, ажлын төсөвт магадлал хийлгэж, батлагдсан зураг, төсвөөр ажил гүйцэтгэх тендерийн баримт бичгийг боловсруулж, тендерийг зарлахаар болсон байгаа. Түлхүүр хүлээлгэн өгөх нөхцлөөр ажлын даалгавар боловсруулагдсан нь тендерийн хуультай хэрхэн нийцэж байгаад хуулийн талаас тайлбар хийнэ үү.

Хариулт: Тендэрт шалгарсан гүйцэтгэгч ажлын даалгаврын дагуу нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэж, тоног төхөөрөмжийг нийлүүлэн барилга угсралтын ажлыг гүйцэтгэн, ашиглалтад хүлээлгэн өгнө.

12. Хийн дулааны станц баригдах газрын гэрчилгээ, кадастер, талбайн хэмжээний талаархи мэдээлэл Ажлын даалгаварт байхгүй байна. Энэ яаралтай гаргаж өгнө үү. Энэ нь төлөвлөлт хийгдэхэд шаардлагатай байна. Ажлын даалгаврын 8.Төслийн ажлын ерөнхий шаардлага хэсэгт заасны дагуу Түлхүүр хүлээлгэх нөхцөлөөр ажил гүйцэтгэх Техникийн санал боловсруулах гэж ойлгогдож байна. Үүнийг баталгаажуулна уу.

Хариулт:

Хийн дулааны станц баригдах газрын гэрчилгээ, кадастер, талбайн хэмжээний талаархи мэдээлэл 2-р үе шатанд тодорхой болно. /Хавсралтаар оруулав./

13. Ажлын зураг төслийг боловсруулж, холбогдох төрийн байгууллагуудаар хянуулж, Архитектор төлөвлөлтийн даалгавар, эскизийг батлуулж, магадлан хийлгүүлэхээр тусгасан байна. Харин ажлын төсвийг боловсруулах, магадлангаар оруулах эсэх тусгагдаагүй байна. Дээрхи ажлууд хийгдэх, хийгдэхгүй эсэх талаар баталгаажуулна уу.

Хариулт:

Газрын асуудал шийдэгдэхэд гүйцэтгэгч компани ажлын зураг, төсвийг боловсруулж эрх бүхий байгууллагаар баталгаажуулан магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулна.

14. Ажлын даалгаварт төслийг эхлүүлэх, хэрэгжүүлж дуусгах хугацааны талаар мэдээлэл хомс байна. Хугацааг баталгаажуулж өгнө үү.

Хариулт:

Төсөл арга хэмжээний барилга угсралтыг ажлыг 2026 оны 09 дүгээр сард багтаан улсын комисс ажиллуулан, ашиглалтад оруулсан байна.

15. Төслийн Инженер, геологийн судалгаа, дүгнэлт, Геодезийн судалгаа дүгнэлт, Усны судалгаа, дүгнэлтийг Гүйцэтгэгч хийхээр байгааг баталгаажуулна уу.

Хариулт: Хийн дулааны станц баригдах газрын гэрчилгээ, кадастерыг албажуулан оролцогч нарт 2-р үе шатны тендерийн баримт бичигт тусгагдан хүргүүлнэ. "Бусад ажлуудыг гүйцэтгэгч хариуцна".

16. Техникийн санал боловсруулахад Гүйцэтгэгчид шаардлагатай байгаа мэдээлэл, тоо баримт Ажлын даалгаварт тусгагдаагүй бол Захиалагчийн зүгээс хэн хариуцах, зохион байгуулах талаар мэдээлэл өгнө үү.

Хариулт: Ажлын даалгаварт тусгагдаагүй техникийн саналыг оролцогч тендерийн баримт бичигт хавсаргасан урьдчилсан зургийг сайжруулах байдлаар саналаа ирүүлж болно.

17. Ажлын даалгаварт Хийн хангамжийн хэсгийн техникийн шаардлага, үндсэн үзүүлэлтүүд байхгүй байна. Энэ мэдээллийг баталгаажуулна уу.

Хариулт: Ажлын даалгаварт үндсэн үзүүлэлт тусгагдсан байгаа бөгөөд техникийн саналыг оролцогч тендерийн баримт бичигт хавсаргасан урьдчилсан зургийг сайжруулах байдлаар саналаа ирүүлж болно.

18. ТЭЗҮ-г нарийвчилсан ТЭЗҮ гэж тооцож болох эсэх. Урьдчилсан ТЭЗҮ хийгдсэн эсэх. ТЭЗҮ дээрх техникийн тоон үзүүлэлтийг тооцоололд шууд авч ашиглах боломжтой эсэх.

Хариулт: Боломжтой. Техник эдийн засгийн үндэслэлийг сайжруулах байдлаар саналаа ирүүлж болно.